



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/116

Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн "Аймгийн 2024 оны төсөв батлах тухай" 23/14 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтын 7 дугаарт батлагдсан Зарим сумдад автомашин, төрийн байгууллагуудад дуудлагаар үйлчлэх автомашин худалдаж авах зардлаас аймгийн Цагдаагийн газарт автомашин авах зардалд 45,000,000, (дөчин таван сая) Прокурорын газарт автомашин авах зардалд 33,000,000 (гучин гурван сая) төгрөг, нийт 78,000,000 (далан найман сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Худалдан авах ажиллагааны газарт даалгасугай.

3. Санхүүжилтийг хуваарийн дагуу олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

6224 11 0241